



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ИХЭНХ ХУВИЙГ ЖИЖИГ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

2025 оны 06 дугаар сар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Аудитор: В.Хуандаг

Утас: 99426960 Цахим хаяг: Khuandikhv@audit.gov.mn

2025 он

АГУУЛГА	1
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёог	4
Дүрслэлийн товъёог	4
Зургийн товъёог	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
1.1. СУМУУД МАЛЫН ТОО, ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ДУТУУ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	7
1.1.2.ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна.....	7
1.1.3. Аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна.....	8
1.1.4. Малын тоо, толгойн албан татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна..	9
1.2. ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТУХАЙН ШАТНЫ ИТХ-ААР БАТЛУУЛАН ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ ГАРСААР БАЙНА	11
1.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 44.2 хувь нь иргэдийн саналаар дэмжигдээгүй байна.....	11
1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулсан байна.....	13
1.2.3. Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.....	13
1.2.4 ОНХС-ийн чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг тусгасан байна.....	14
2.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ИХЭНХ ХУВИЙГ ХЭТ ЖИЖИГ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААЖ ЗАРЦУУЛСНААР БОДИТ ҮР ДҮНД ХҮРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА	16
2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 93.0 хувийг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан байна.....	16
2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ТАХ-г зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулаагүй байна.....	18
2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БОДИТ ХУВЬ НЭМЭР ӨГӨХҮЙЦ ТАХ ЦӨӨХӨН ХЭРЭГЖСЭН БАЙНА ..	20
2.2.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд зорилтод түвшинд хүрсэн байна.....	20
2.2.2. ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлснээр үр дүнд нөлөөлж орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц ТАХ цөөхөн хэрэгжсэн байна.....	21
2.3.ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ЗОХИСТОЙ БАЙНА.	23
2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.6 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна	23
2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.	24
3.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗОХИХ ТҮВШИНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА	25
3.1.1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, дотоод аудит хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.....	25
3.1.2.Захиалагчийн хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлэн ажилласан байна.....	26
3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын 78.8 хувийг хэрэгжүүлсэн байна.	27
3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА.	27
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь Сангийн яамд тайлагнасан байна.....	27
3.2.2.ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 248.7 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.....	28
3.2.3. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд 2 сум мэдээллийг оруулаагүй байна.....	29
3.2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.	31
ДҮГНЭЛТ:	31
ЗӨВЛӨМЖ:	32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УМС	Удирдлагын мэдээллийн систем

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНХС-ийн суурь тооцоолол	8
Хүснэгт 2	ОНХНС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 3	Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, санхүүжилт	9
Хүснэгт 4	Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт	10
Хүснэгт 5	Сумдын малын тоо, толгойн судалгаа	11
Хүснэгт 6	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний чиг үүргийн ангилал	15
Хүснэгт 7	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	17
Хүснэгт 8	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний судалгаа	20
Хүснэгт 9	ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалт, үр дүн	22
Хүснэгт 10	Хөрөнгийн ашиглалтын байдал	25
Хүснэгт 11	Аймаг, сумын ОНХС-ийн мэдээллийг УМС-д мэдээлсэн байдал	32

Дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний чиг үүргийн ангилал	16
Дүрслэл 2	Зохих үр дүнд хүрсэн ТАХ-ний ангилал	22
Дүрслэл 3	ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 574 ТАХ-ний үр дүнг ашиглагч байгууллагуудаас авсан судалгаа	25

Зургийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Ногоон байгууламжийн усалгааны шуудууг сэргээн засварласан байдал	24
Зураг 2	Нарны цэнэгтэй ба цахилгааны эх үүсвэртэй гэрэлтүүлгийн ажил	24
Зураг 3	Улаанхус сумын Хөх хөтөл багийн Эрүүл мэндийн төвийн засварын ажил	24

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянасан, тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнг аймаг, сумын ИТХ, Засаг дарга, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба, Барилга захиалагчийн алба зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020 “Чанарын хяналт”, 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудит”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, С.Нурлан аудитор Х.Манаргүл, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, В.Хуандаг нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 5 дугаар сарын 19-ний өдрөөс 6 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, тайлагнах үе шатны ажлыг 2024 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 7 дугаар сарын 01-ны хооронд хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Зарим сумдын ОНХС хариуцсан зарим албан хаагчид өөрчлөгдснөөс аудитад шаардлагатай баримт материалыг тухайн үед гаргаж өгөөгүй нь хүндрэлтэй байв.

1.1. СУМУУД МАЛЫН ТОО, ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ДУТУУ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

1.1.2.ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна

Сангийн яам ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2¹, 59.3² дахь заалт, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хүн амын тоо, нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн тооцсон байна.

ОНХС-ийн суурь тооцооллыг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №01 ОНХС-ийн суурь тооцоолол

(сая төгрөг)

Сумын нэр	Итгэлцүүрээр хуваарилагдах нийт дүн	Өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ /ЖГҮ/	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	Сумдын ОНХС-д хуваарилагдах суурь дүн
Алтай сум	283.5	69.6	-	2.6	355.7
Алтанцөгц сум	269.3	-	47.5	9.4	326.2
Баяннуур сум	222.7	-	22.5	-	245.2
Бугат сум	188.6	-	8.8	-	197.4
Булган сум	413.8	-	-	4.3	418.2
Буянт сум	153.7	-	3.8	-	157.5
Дэлүүн сум	659.0	-	25.6	17.3	702.0
Өлгий сум	839.4	-	0.5	-	839.9
Ногооннуур сум	737.6	-	3.9	27.9	769.4
Сагсай сум	818.6	57.1	2.9	24.2	902.7
Толбо сум	625.6	-	-	31.9	657.5
Улаанхус сум	711.6	108.5	-	17.4	837.5
Цэнгэл сум	875.5	-	21.9	27.0	924.5
Цагааннуур	50.0	-	-	-	50.0
Сумын дүн	6,848.9	235.2	137.4	162.0	7,383.6
Аймагт хуваарилагдсан	4,565.9	-	-	-	4,565.9
Нийт дүн	11,414.9	235.2	137.4	162.0	11,949.5

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн CTCX

ОНХНС-аас аймаг, сумын ОНХС-д олгох суурь тооцооллыг итгэлцүүрээр олгох 6,848.9 сая төгрөг, өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний 235.2 сая төгрөг, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 137.4 сая төгрөг, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн 162.0 сая төгрөг, нийт 7,383.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Сангийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” 152 дугаар тушаалаар ОНХНС-аас аймгуудад олгох орлогын

¹ Аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна

² Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

шилжүүлгийн хуваарийг баталсан байна. Баян-Өлгий аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарийг дараах байдлаар баталж, санхүүжүүлсэн байна.

Хүснэгт №02 ОНХС-аас аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)

Санхүүжилт улирлаар	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1-р улиралд олгох санхүүжилт	2,019.5	2,019.5	0.0
2-р улиралд олгох санхүүжилт	3,104.0	3,079.0	25.0
3-р улиралд олгох санхүүжилт	3,239.8	3,162.1	77.7
4-р улиралд олгох санхүүжилт	3,586.2	3,206.5	379.7
нийт	11,949.5	11,467.1	482.4

Эх сурвалж: Сангийн Яам, аймгийн CTCX

Тус аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2 дугаар улиралд 25.0 сая төгрөгөөр, 3 дугаар улиралд 77.7 сая төгрөгөөр, 4 дүгээр улиралд 379.7 сая төгрөгөөр, нийт дүнгээр 482.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

1.1.3. Аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгосон байна

Сангийн сайдын 2023 оны 281 дугаар тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон нутгийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” А/924 дүгээр захирамжаар ОНХС-аас сумдад олгох санхүүжилтийн хуваарийг баталсан байна.

Тайланд онд орон нутгийн төсөвт 2 удаа тодотгол хийгдэж ОНХС-ийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

ОНХС-аас аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн сар улирлын хуваарийн хэрэгжилтийг авч үзэхэд санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна.

Хүснэгт №03 Аймаг, сумдын ОНХС-ийн хуваарилалт, санхүүжилт (сая төгрөг)

Санхүүжилт улирлаар	аймаг, сум	Улирлын санхүүжилтийн хуваарь	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1-р улирал	Аймаг	1,395.2	783.3	611.9	56.1
	Сум	979.7	1,236.1	(256.5)	126.2
	Нийт	2,374.9	2,019.5	355.4	85.0
2-р улирал	Аймаг	1,243.9	1,186.0	57.9	95.3
	Сум	1,860.8	1,893.0	(32.2)	101.7
	Нийт	3,104.7	3,079.0	25.7	99.2
3-р улирал	Аймаг	1,076.6	1,214.7	(138.1)	112.8
	Сум	1,704.4	1,947.4	(243.0)	114.3
	Нийт	2,781.0	3,162.1	(381.1)	113.7
4-р улирал	Аймаг	850.2	1,200.1	(349.9)	141.2
	Сум	2,838.8	2,006.4	832.4	70.7
	Нийт	3,689.0	3,206.5	482.5	86.9
Нийт	Аймаг	4,565.9	4,384.2	181.8	96.0
	Сум	7,383.6	7,082.9	300.7	95.9
	Нийт	11,949.5	11,467.1	482.4	96.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Сумын ОНХС-д 1 дүгээр улиралд 256.5 сая төгрөгөөр, 2 дугаар улиралд 32.2 сая төгрөгөөр, 3 дугаар улиралд 243.0 сая төгрөгөөр батлагдсан хуваариас илүү олгосон бол 4 дүгээр улиралд 832.4 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Аймгийн ОНХС-д 1 дүгээр улиралд 611.9 сая төгрөгөөр, 2 дугаар улиралд 57.9 сая төгрөгөөр дутуу олгосон бол 3 дугаар улиралд 138.1 сая төгрөгөөр, 4 дүгээр улиралд 349.9 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Нийт дүнгээр авч үзвэл аймаг, сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 96 хувиар буюу тэнцүү хэмжээгээр хуваарилсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас авбал зохих нийт санхүүжилтийн 96 хувийг буюу 11,467.1 сая төгрөгийн санхүүжилт авч улсын хэмжээнд ОНХС-ийн эх үүсвэр дутуу бүрдсэнээс 4 хувь буюу 482.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

1.1.4. Малын тоо, толгойн албан татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байна

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2³-ийн 60.2.4⁴, 60.2.8⁵-д орон ОНХС-ийн бүрдүүлэх эх үүсвэрийг талаар тусгасан. Баян-Өлгий аймгийн хувьд орон нутгийн өөрийн орлогын гол эх үүсвэр нь малын тоо толгойн татварын орлого байна.

Сумдын ОНХС-ийн 2024 оны эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогыг 445.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 167.9 сая төгрөгийн татвар оруулсан байна.

Хүснэгт № 04 Аймаг, сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлт (сая төгрөг)

№	Сум, дүүргийн нэр	2024 оны Орон нутгийн өөрийн орлогын эх үүсвэр						Нийт эх үүсвэр	
		ИТХ-ын тогтоолоор баталсан ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл		Бусад орлого		Малын тоо толгойн албан татвар		төлөв	гүйц
		төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц		
1	Алтай сум	-	-	-	-	5.6	-	5.6	-
2	Алтанцөгц сум	43.1	45.1	-	-	-	-	43.1	45.1
3	Баяннуур сум	135.0	8.5	14.0	98.5	-	-	233.5	22.5
4	Булган сум	115.7	115.7	1.0	55.4	30.5	-	171.1	147.2
5	Бугат сум	25.0	25.0	-	8.5	8.5	-	33.5	33.5
6	Буянт сум	-	-	-	35.0	24.2	-	35.0	24.2
7	Дэлүүн сум	73.2	73.2	-	40.0	40.0	-	113.2	113.2
8	Ногооннуур сум	76.7	76.7	12.5	10.6	-	-	87.3	89.2
9	Сагсай сум	5.2	5.2	-	28.0	28.0	-	33.2	33.2
10	Толбо сум	63.6	4.4	-	26.8	-	-	90.4	4.4
11	Улаанхус сум	72.9	72.9	4.8	21.7	21.7	-	94.6	99.4

³ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ”,

⁴ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

⁵ малын тоо толгойн албан татварын орлого.

12	Цэнгэл сум	-	-	-	115.5	15.0	115.5	15.0
13	Цагааннуур тосгон	-	-	-	-	-	-	-
14	Өлгий сум	0	0	0	0	0	-	-
	Сумын дүн	610.3	426.6	-	32.3	445.6	167.9	1,055.9
15	Аймгийн ОНХС	-	-	-	-	-	-	-
	Нийт дүн	610.3	426.6	-	32.3	445.6	167.9	1,055.9

Эх сурвалж: ОНХС-гийн эх үүсвэрийн төлөвлөлтөд хийсэн аудитын судалгаа

Сумуудаас ирүүлсэн малын тоо толгойн статистик тоо, мэдээллийн судалгаанаас харахад дараах байдалтай байна.

Хүснэгт № 05 Сумдын малын тоо, толгойн судалгаа (сая төгрөг)

№	Сумын нэр	Малын тоо толгойн албан татвар ногдуулах малын тоо	Ногдуулбал зохих малын тоо толгойн албан татварын дүн	Малын тоо толгойн албан татвар		Зөрүү	
				Төлөв	Гүйц	7=4-5	8=6-5
1	2	3	4	5	6	7=4-5	8=6-5
1	Алтай сум	66,478	16.9	-	-	-16.9	-
2	Алтанцөгц сум	138,203	74.2	-	-	-74.2	-
3	Баяннуур сум	154,467	49.1	98.5	-	49.4	-98.5
4	Бугат сум	120,856	41.4	8.5	8.5	-32.9	-
5	Булган сум	93,520	36.1	55.4	30.5	-19.3	-24.9
6	Буянт сум	150,274	32.6	35.0	24.2	-2.4	-10.8
7	Дэлүүн сум	162,587	130.0	40.0	40.0	-90.0	-
8	Ногооннуур сум	257,394	116.1	10.6	-	-105.5	-10.6
9	Сагсай сум	156,600	43.7	28.0	28.0	-15.7	-
10	Толбо сум	113,437	36.1	26.8	-	-9.3	-26.8
11	Улаанхус сум	172,530	85.2	21.7	21.7	-63.5	-
12	Цагааннуур	30,742	13.8	-	-	-13.8	-
13	Цэнгэл сум	261,216	118.1	115.5	34.0	-2.6	-81.5
14	Өлгий сум	26,188	15.0	-	-	-15.0	-
	Нийт	1,904,492	808.3	440.0	186.9	-368.3	-253.1

Эх сурвалж: Аудитын судалгаа

Алтай, Алтанцөгц, Өлгий сум, Цагааннуур тосгон малын тоо, толгойн албан татвараас орох орлогыг төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлээгүй байна.

Баяннуур, Булган сум ногдуулбал зохих татвараас илүү төлөвлөж, Бугат, Сагсай, Улаанхус, Дэлүүн, Ногооннуур, Толбо сум, Цэнгэл сум дутуу төлөвлөсөн байна.

Аудитаар ногдуулбал зохих малын тоо, толгойн татвараас орох орлогыг бодитой тооцож, ОНХС-ийн төлөвлөгөөнд нэмж төлөвлөн, ОНХС-ийн журамд заасан чиг үүргийн хүрээнд орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г санхүүжүүлэхийг зөвлөмж болгов.

Аймаг, сумын ОНХС Төсвийн тухай хуулийн 60.2-ийн 60.2.4.-т “татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр” гэж заасны дагуу бусад эх үүсвэрээс орлого бүрдүүлэлтийн талаар судлаагүй байна.

1.2. ИРГЭДИЙН САНАЛ АВААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТУХАЙН ШАТНЫ ИТХ-ААР БАТЛУУЛАН ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЗӨРЧИЛ ГАРСААР БАЙНА

1.2.1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 44.2 хувь нь иргэдийн саналаар дэмжигдээгүй байна

Сумын Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан, ажлын хэсэг багуудаас ирсэн саналыг эрэмбэлж сумын Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

Сумуудын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй нийт 94 төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймагт хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсэг хөгжлийн бодлоготой уялдуулан хянаж, 54 төсөл, арга хэмжээг эрэмбэлж, төлөвлөн аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна.

Сангийн сайдын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5.2-д заасны дагуу 2023 онд 755 төсөл, хөтөлбөрт давхардсан тоогоор нийтдээ 63,621 иргэнээс санал авсан байна. Үүнээс 94.0 хувийг буюу 59,759 саналыг цаасаар, 3.4 хувийг буюу 2,185 саналыг бүлгийн ярилцлагаар, 2.6 хувийг буюу 1,677 саналыг цахимаар авсан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт давхардсан тоогоор нийт 3,957 иргэнээс санал авсанаас цаасаар 3,815, бүлгийн ярилцлагаар 130, цахимаар 12 санал авсан байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт давхардсан тоогоор нийт 59,664 иргэнээс санал авсанаас цаасаар 55,944, бүлгийн ярилцлагаар 2,055, цахимаар 1,665 санал тус тус авсан байна.

Аймгийн хэмжээнд иргэдээс нийт 755 ТАХ-нд санал өгсөнөөс 48.0 хувь буюу 363 ТАХ-г аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор батлуулсан байна.

Аймаг, сумын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй, цөөхөн иргэнээс санал авсан, төсөвт багтаагүй гэх шалтгаанаар 392 ТАХ эрэмбэд ороогүй цуцлагдсан байна. /Судалгаа №10-аас дэлгэрэнгүй харна уу/

Булган сумын ОНХС-гийн иргэдээс санал авсан, эрэмбэлсэн талаарх холбогдох баримт материалыг аудитад ирүүлээгүй тул дээрх судалгаанд ороогүй болно.

Алтай, Алтанцөгц, Баяннуур, Толбо, Сагсай сум иргэдээс санал авч, эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн бол иргэдийн санал аваагүй, эрэмбэд ороогүй Бугат сум 7, Буянт сум 14, Өлгий сум 26, Дэлүүн сум 40, Ногооннуур сум 48, Улаанхус сумд 51, Цэнгэл сум 12, Цагааннуур тосгон 3 ТАХ-г сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн байна.

Дээрх асуудал нь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтыг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан бэлтгэж танилцуулах ажил хангалтгүй, иргэдээс санал авах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, багийн ИНХ-ыг хангалтгүй ирцтэйгээр зохион байгуулсан, иргэд, олон нийтийн ОНХС-ийн талаар мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна.

Сумын иргэдийн ихэнх нь хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг дэмжих зорилгоор худаг гаргах, зам засах, гэрэлтүүлэг тавих, хадлан хаших гэх мэт ажлуудад санал өгсөн нь эрэмбэд орохгүй үлдэхэд нөлөөлсөн байна.

Аймаг, сумын Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тусгагдсан, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц ажлын талаар иргэдийн ойлголт дутмаг, маш цөөхөн саналаар дэмжигдсэн зарим ТАХ-г аймаг, сумын Засаг дарга нар тухайн шатны ИТХ-д уламжлан батлуулсан тохиолдол байна.

Иймд урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөө, аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан, ТЭЗҮ, зураг төсөв бэлэн болсон бусад төлөвлөлтийн шаардлага хангасан, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор хэрэгжүүлэх боломжоор хангах талаар хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Аймаг, сумын Засаг дарга нарын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан иргэдийн санал аваагүй ТАХ-г тухайн шатны ИТХ-ын тогтоолоор батлуулж хэрэгжүүлсэн ажлуудаас дурьдвал;

- Сумын ЗДТГ-ын албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах;
- Хүүхдийн цэцэрлэгийг гадна тоглоомын талбайтай болгох;
- Боловсролын байгууллагын менежментийг сайжруулж, багш нарыг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд “Багшийн хөгжлийн танхим байгуулах”;
- Сумын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хийх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх барилгын зураг төсөл хийлгэх;
- Боловсролын сайдаас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” төслийн хүрээнд зарим сургуулийг хяналтын камертай болгох;
- Цагдаагийн газрын сумын Засаг даргатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу цагдаагийн кабоны урсгал засвар;
- ХХЕГ-аас ирсэн чиглэлийн дагуу баруун Улаанхус сумд байрладаг агаарын цэргийн 116 дугаар ангийн хоноглох байр барих төсөл арга хэмжээ.

Аудитын илрүүлэлт:

- *Аймгийн ОНХС-аас иргэдийн саналыг авч эрэмбэлэгдээгүй 370.4 сая төгрөгийн 23 ТАХ-г аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлсэн.*
- *Сумын ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт хамааралтай боловч иргэдийн саналаар дэмжигдээгүй дараах ТАХ хэрэгжүүлсэн байна. Үүнд:*
 - *Буянт сум 80.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ,*
 - *Өлгий сум 255.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 ТАХ,*
 - *Цэнгэл сум 210.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ,*
 - *Ногооннуур сум 54 ТАХ-г хэрэгжүүлэн ажилласан байна.*

Аудитын дүнгээр иргэдийн саналыг авч эрэмбэлэгдээгүй ТАХ-г тухайн шатны ИТХ-ын тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байгаа зөрчлийг арилгах, хууль тогтоомж биелүүлж ажиллах талаар аймаг, сумын Засаг дарга нарт албан шаардлага, аймгийн ИТХ-ын даргад зөвлөмж хүргүүлэв.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулсан байна

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, мөн өдрийн 14 дүгээр тогтоолоор 21 зорилт, 118 дэд зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байна.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Хөгжлийн төлөвлөгөө, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр гаргаж, тайлагнаж ажилласан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.1-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх” гэж заасныг баримталж Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.2.3. Төсвийн тухай хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан 6,106.0 сая төгрөгийн 112 ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөв болон хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний ихэнхи нь Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан боловч дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ✓ Ногооннуур сум өмнөх оноос шилжих 96.4 сая төгрөгийн 15 ТАХ-г ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй зарцуулсан, 5.7 сая төгрөгийг сонгуулийн сурталчилгааны самбар байршуулахад төлөвлөн батлуулсан;
- ✓ Бугат сум 3.8 сая төгрөгийг сонгуулийн сурталчилгааны самбар байршуулахад төлөвлөн батлуулсан, 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын хаягтай хаалга” ТАХ-г төлөвлөгөөнд оруулан урьд оны үлдээгдлээс санхүүжүүлэхээр тусгасан.
- ✓ Улаанхус сум Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Угтах хаалга” барих ажлыг төлөвлөж батлуулсан байна.

Аудитын дүнгээр төсвийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г хэрэгжүүлэхгүй байх талаар Бугат, Ногооннуур, Улаанхус сумын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлэв.

1.2.4 ОНХС-ийн чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг тусгасан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2⁶-т аймаг, нийслэлийн түвшинд, 4.4⁷,4.5⁸-т сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тусгасан.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 6,106.0 сая төгрөгийн 112 ТАХ, сумдын ИТХ-ын тогтоолоор 8,683.2 сая төгрөгийн 674 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөж тухайн шатны ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр тухайн онд 5,315.5 сая төгрөгийн 100 ТАХ буюу 45.7 хувь, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 6,314.0 сая төгрөгийн 566 ТАХ буюу 54.3 хувийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г журамд заасан чиг үүрэгт нийцсэн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №06 Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний чиг үүргийн ангилал

(сая төгрөг)

Журмын чиг үүргийн заалт	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Эзлэх хувь
Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи	45	1,053.4	19.8
Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ	28	2,036.7	38.3
Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах	8	596.9	11.2
Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	7	1,183.5	22.3
Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах	6	295.3	5.6
Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах	3	100.2	1.9
Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй	3	49.5	0.9
Нийт дүн	100	5,315,5	100

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт хамааралгүй 35.0 сая төгрөгийн дараах 2 ТАХ хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

⁶ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаагаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

⁷ Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаагаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

⁸ Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Өлгий сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн их засварын зураг, төсвийн дутуу олгосон 15.0 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон (аймгийн ИТХ-ын баталсан жагсаалтад ороогүй);
- ОНХС-ийн чиг үүрэгт хамааралгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 20.0 сая төгрөгийн Өлгий сумын 11 дүгээр багийн нийтийн орон сууцны орцны засварын ажлыг “Эмпория” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн байна.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г журамд заасан чиг үүрэгт нийцсэн байдлыг дүрслэлээр харуулбал;

Дүрслэл № 01 Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний чиг үүргийн ангилал



- “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийн хүрээнд 154 ТАХ-нд 1410.6 сая төгрөг;
- “Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ” чиг үүргийн хүрээнд 183 ТАХ-нд 2,454.0 сая төгрөг;
- “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах” чиг үүргийн хүрээнд 101 ТАХ-нд 1,010.0 сая төгрөг;
- Малын тоо толгойн албан татварын орлогоос чиг үүргийн дагуу 77 ТАХ-нд 870.1 сая төгрөг;
- “Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулах” чиг үүргийн хүрээнд 32 ТАХ-нд 346.8 сая төгрөг;
- “Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулах” чиг үүргийн хүрээнд 6 ТАХ-нд 131.6 сая төгрөг;
- “Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн чанарыг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд 6 ТАХ-нд 61.9 сая төгрөг;
- “Ажлын байр бий болгох” чиг үүргийн хүрээнд 1 ТАХ-нд 7.0 сая төгрөг
- Журамд заасан чиг үүрэгт хамааралгүй 21.3 сая

төгрөгийн 6 ТАХ байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр чиг үүрэгт хамааралгүй дараах ТАХ хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

- Булган, Ногооннуур, Толбо сум, Цагааннуур тосгон нь чиг үүрэгт хамааралгүй 27.2 сая төгрөгийн 7 ТАХ-г сонгуулийн сурталчилгааны самбар, онцгой комиссын гишүүдийн хувцас, тамгын газрын ажилчдын сургалтын зардал г.м үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Аудитаар тухайн шатны Хурлын тогтоолоор баталсан жагсаалтад ороогүй, ОНХС-ийн чиг үүрэгт хамааралгүй ТАХ-г хэрэгжүүлэхгүй байх, хууль тогтоомж мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөгдсөн.

2.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ИХЭНХ ХУВИЙГ ХЭТ ЖИЖИГ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНД ХУВААЖ ЗАРЦУУЛСНААР БОДИТ ҮР ДҮНД ХҮРЧ ЧАДАХГҮЙ БАЙНА

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 93.0 хувийг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан байна

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 1,101.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 52 ТАХ, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 7,099.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 562 ТАХ нийт 8,200.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 614 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Тендер зохион байгуулсан нийт ажлын 12.6 хувь буюу 1,035.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтаар, 12.6 хувь буюу 1,031.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 ТАХ-г харьцуулалтын аргаар, 74.8 хувь буюу 6,134.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 574 ТАХ-г шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. (судалгаа 2-аас харна уу)

Хүснэгт №07 Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт

(сая төгрөг)

Аймаг, сумын нэр	ХАА-г зохион байгуулагдсан ТАХ		Үүнээс						Гэрээ шууд байгуулсан ТАХ-ний эзлэх хувь /ТАХ-ний тоогоор	Гэрээ шууд байгуулсан ТАХ-ний эзлэх хувь /мөнгөн дүнгээр/
			Нээлттэй тендер шалгаруулалт		Онцгой журам					
					Харьцуулалт		Гэрээ шууд байгуулах			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Алтай сум	23	348.7	1	80.0	1	20.0	21	248.7	91	71
Алтанцөгц сум	16	186.4		-		-	16	186.4	100	100
Баяннуур сум	27	320.9	1	94.4		-	26	226.6	96	71
Булган сум	55	411.1		-	1	45.0	54	366.1	98	89
Бугат сум	23	138.7		-		-	23	138.7	100	100
Буянт сум	19	112.6		-		-	19	112.6	100	100
Дэлүүн сум	43	428.1		-	4	109.0	39	319.1	91	75
Ногооннуур сум	62	757.0		-	3	85.9	59	671.1	95	89
Сагсай сум	22	835.2	2	281.1	5	351.4	15	202.7	68	24
Толбо сум	66	669.9	2	75.0		-	64	594.9	97	89
Улаанхус сум	75	877.2	4	152.4		-	71	724.7	95	83
Цэнгэл сум	66	1,230.1	7	352.6		-	59	877.5	89	71
Цагааннуур тосгон	7	37.0		-		-	7	37.0	100	100
Өлгий сум	58	746.4		0		0.0	58	746.40	100	100

Сумын дүн	562	7,099.1	17	1,035	14	611	531	5,452	94	77
Аймгийн ОНХС	52	1,101.6	-	-	9	420.0	43	681.6	83	62
Нийт дүн	614	8,200.7	17	1,035.5	23	1,031.3	574	6,134.0	93	75

Эх сурвалж: ХАА-д хийсэн аудитын судалгаа

Судалгаанаас харахад Алтанцөгц, Бугат, Буянт, Өлгий сум болон Цагааннуур тосгон нь 100 хувь гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалт хийсэн байна.

Бусад сумын хувьд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг тоогоор нь авч үзвэл 91.0-98.0 хувь, мөнгөн дүнгээр авч үзвэл 71.0-89.0 хувийг (Сагсай сумаас бусад) мөн гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалт хийсэн байна.

Аймгийн ОНХС-ийн зохион байгуулсан худалдан авах ажиллагааг ТАХ-ний тоогоор нь авч үзвэл 17.3 хувь, мөнгөн дүнгээр авч үзвэл 38.0 хувийг харьцуулалтын аргаар, гэрээ шууд байгуулсан худалдан авалтыг тоогоор авч үзвэл 82.7 хувь, мөнгөн дүнгээр авч үзвэл 62 хувийг тус тус эзэлж байна.

Тендер зохион байгуулсан дүнгээс харахад ихэнх ТАХ-г хэт жижиглэн, гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан, зураг төсвийг баталсан төсөвт өртөгт тааруулж зохиодог зөрчил жил болгон давтгагдсаар байна.

Иймд аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц үр өгөөжтэй ТАХ төлөвлөх нь зүйтэй байна.

Аймаг, сумын Засаг даргын захирамжаар байгуулсан үнэлгээний хороод нь тендерийн бичиг баримтыг ТБОНӨХБАҮХАТ хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”, Засгийн газрын 2023 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах, журам”-ын дагуу боловсруулж ажилласан байна.

Аудитын дүнгээр аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулж, тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа асуудалд дүгнэлт хийж, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцсэн үр өгөөжтэй ТАХ төлөвлөж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт зөвлөмж болгов.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлсэн Өлгий сумын багуудын төвд гэрэлтүүлэг тавих 174.3 сая төгрөгийн дүнтэй ажлыг 10 хувааж гэрээ шууд байгуулсан;
- Өлгий сумын 26, 27, 28 дугаар цэцэрлэгт хатуу, зөөлөн эдлэл нийлүүлэх 97.1 сая төгрөгийн ажлыг 5 хувааж гэрээ шууд байгуулсан;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 35.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй Алтанцөгц сумын Соёлын төвд нийлүүлсэн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2 хувааж гэрээ шууд байгуулж гүйцэтгүүлсэн.

- Бугат сум 43.0 сая төгрөгийн аюулгүйн нөөц бүрдүүлэх (хорголжин хивээг) ажлыг 3 хувааж гэрээ шууд байгуулсан.
- Булган сум 46.0 сая төгрөгийн дүнтэй Сумын ЗДТГ-ын засвар хийх ажлыг 3 хувааж шууд шууд байгуулсан;
- Толбо сум Соёлын төвд тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэхийг ажлыг 4, сумын 2,6 дугаар багийн төвийн барилга барих ажлыг 2 ажил болгон хувааж гэрээ шууд байгуулсан, сумын ЗДТГ, ИТХ, Багийн засаг дарга, ЕБС, Соёлын төвд худалдан авсан 80.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй.
- Буянт сум сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвд 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл арга хэмжээг цахим дэлгүүрээс худалдан аваагүй.
- Цэнгэл сум ЕБ-ын 2 дугаар сургуульд цахим анги байгуулах 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

Аудитын дүнгээр холбогдох хууль тогтоомж зөрчин гэрээ шууд байгуулсан, цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс нийлүүлээгүй зөрчлүүдэд зөрчил арилгах албан шаардлага өгөв.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим ТАХ-г зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулаагүй байна

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 666 төсөл, арга хэмжээнд 11,629.6 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 10,783.7 сая төгрөгийн 86.2 хувь буюу 574 ТАХ бүрэн хэрэгжиж, 12.3 хувь буюу 82 ТАХ хэрэгжих шатанд, 4.3 хувь буюу 29 ТАХ огт хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, хугацаа хожимдож гэрээ байгуулсан, малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт тасарснаас санхүүжилт хүрэлцээгүй зэргээс шалтгаалан 29 ТАХ хэрэгжээгүй байна.

Хүснэгт №08 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний судалгаа

(сая төгрөгөөр)

№	Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Гэрээ байгуулсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
		тоо	дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	Гэрээний дүн	тоо	дүн
1	2	3	4	5	6	7	8	11	12	14	15
1	Өлгий сум	68	867.90	68	854.46	62	780.46	0	-	6	74.0
2	Алтай сум	28	367.0	24	324.4	24	324.39				
3	Алтанцөгц сум	20	369.3	16	186.4	16	186.41	-	-	-	-
4	Баяннуур сум	40	639.4	27	326.9	25	296.93	2	30.0	-	-
5	Булган сум	77	577.8	69	531.2	62	459.44	7	71.7	-	-
6	Бугат сум	33	230.9	23	138.7	22	131.66	1	7.0	-	-
7	Буянт сум	22	187.8	22	127.8	22	127.78			-	-
8	Дэлүүн сум	67	815.2	52	512.1	24	172.60	23	322.0	5	17.50

9	Ногооннуур сум	61	732.0	50	551.4	40	415.25	10	136.1	-	-
10	Сагсай сум	28	935.9	25	863.3	25	863.3				
11	Толбо сум	73	747.9	56	543.0	35	344.79	21	198.2	-	-
12	Улаанхус сум	82	932.1	75	877.2	61	730.53	10	98.6	4	48.0
13	Цэнгэл сум	66	1,230.1	56	963.3	51	925.19	5	38.1	-	-
14	Цагааннуур тосгон	9	50.0	8	41.0	8	41.00	-	-	-	-
	сумын дүн	674	8,683.2	571	6,841.0	477	5,799.8	79	901.7	15	139.5
15	Аймгийн	112	6,106.05	114	6,059.38	97	4,983.88	3	619.5	14	456.0
	нийт дүн	786	14,789.2	685	12,900.4	574	10,783.7	82	1,521.2	29	595.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитаар ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн зарцуулсан эсэхийг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Зориулалт бус зарцуулсан ТАХ-ний тухайд:

Сумын ОНХС:

- Баяр наадмын зардлыг Өлгий сум 2.0 сая, Буянт сум 3.0 сая, Ногооннуур сум 3.0 сая төгрөгөөр Засгийн газраас тогтоосон жишиг хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан;
- Сонгуулийн сурталчилгааны самбар байршуулахад Булган сум 2.0 сая,, Толбо сум 2.0 сая, Ногооннуур сум 5.7 сая төгрөг зарцуулсан;
- Толбо сум онцгой комиссын 25 гишүүнд хувцас авахад 8.0 сая төгрөг, цахилгаан үүсгүүр авахад 5.0 сая төгрөг зарцуулсан;
- Бугат сум 18.0 сая төгрөгийн “Сумын хаягтай хаалга” ТАХ-г урьд оны үлдэгдлээс зарцуулсан;
- Ногооннуур сум өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтын 96.4 сая төгрөгийн 15 ТАХ-г ИТХ-ын тогтоолоор батлуулаагүй зарцуулсан, Тамгын газрын алба хаагчдын “Монгол бичиг сургах, баримт бичиг төлөвлөх, боловсруулах, албан хэрэг хөтлөх, цахим орчинд хэрэгжүүлэх чадвар эзэмшүүлэх” сургалтын зардалд 2.0 сая төгрөгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан.

Аймгийн ОНХС:

- Аялал жуулчлалын боомтын сэргээлтийн зардлаас тээвэр шатахууны зардалд 20.8 сая төгрөг (овоо тахилгын зардал 10.1 сая төгрөг, хилийн цэргийн 165 дугаар ангид 10.7 сая төгрөг) зарцуулж үр ашиггүй зардал гаргасан;
- ОНХС-ийн чиг үүрэгт хамааралгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй 20.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Өлгий сумын 11 дүгээр багийн нийтийн орон сууцны орцны засвар”-ын ажлыг батлуулан хэрэгжүүлсэн.

Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн ТАХ-ний тухайд:

Сумын ОНХС:

- Бугат сумын “Хатуу багийн зөөлөн, Хүнхээ, Тайвангийн замын засвар” ТАХ-д ажлын гүйцэтгэлээр 50 хувь буюу 3.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч хэрэгжээгүй. гэрээний хугацаа хэтэрсэн;

Аймгийн ОНХС:

- “Улы дала” ХХК гүйцэтгэж байгаа 59.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Өлгий сумын 8 дугаар багт явган хүний зам тавих” ажлыг гэрээний хугацаа дууссан боловч хүлээлгэн өгөөгүй, ажлын гүйцэтгэл 70 хувьтай;
- “ЖЕМНН” ХХК хийж гүйцэтгэж буй 729.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Өлгий сумын цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх” ажлын гэрээний хугацааг 2024.12.25-ны өдөр хүртэл сунгасан боловч дуусаагүй, хэрэгжилт нь 63.0 хувьтай байна.

**Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй ТАХ-ний тухайд:
Сумын ОНХС:**

- Улаанхус сумын 9.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Шар ямаат хадлан хамгаалах”, 19.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Угтах хаалга” 18.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 4-р багийн гэрэлтүүлэг, 2.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5-р багийн “Хадлангийн зам засах” ажлууд нь урьдчилгаа санхүүжилт олгосон боловч огт хэрэгжээгүй, 8.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5-р багийн “Баян зүрх зам засвар”-ын ажлын гэрээний хугацаа хэтэрсэн, хэрэгжилт нь 70 хувьтай байна.

Аймгийн ОНХС:

- Аймгийн ИТХ-аар “өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл” гэж батлуулсан 307.0 сая төгрөгийн 6, шилжих хөрөнгө оруулалтаар батлуулсан 149.0 сая төгрөгийн 8 ТАХ-г огт хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнгээр 2.4 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 926.0 сая төгрөгийн зөрчил арилгах 7 албан шаардлага хүргүүлэв.

2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БОДИТ ХУВЬ НЭМЭР ӨГӨХҮЙЦ ТАХ ЦӨӨХӨН ХЭРЭГЖСЭН БАЙНА

2.2.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд зорилтод түвшинд хүрсэн байна

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 2024 онд 4,983.9 сая төгрөгийн 97, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5,772.4 сая төгрөгийн 477 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж дууссан, барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр хүлээн авсан байна.

Хүснэгт №09 ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалт, үр дүн

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд			
		тоо	гэрээний дүн	хүрсэн ТАХ		хүрээгүй ТАХ	
				тоо	дүн	тоо	дүн
1	Өлгий сум	62	780.5	62	780.5		
2	Алтай сум	24	324.4	24	324.4		
3	Алтанцөгц сум	16	186.4	16	186.4		

4	Баяннуур сум	25	296.9	25	296.9
5	Булган сум	62	459.4	62	459.4
6	Бугат сум	22	131.7	22	131.7
7	Буянт сум	22	127.8	22	127.8
8	Дэлүүн сум	24	172.6	24	172.6
9	Ногооннуур сум	40	415.3	40	415.3
10	Сагсай сум	25	835.9	25	835.9
11	Толбо сум	35	344.8	35	344.8
12	Улаанхус сум	61	730.5	61	730.5
13	Цэнгэл сум	51	925.2	51	925.2
14	Цагааннуур тосгон	8	41.0	8	41.0
	сумын дүн	477	5,772.4	476	5,772.4
15	Аймгийн	97	4,983.9	97	4,983.88
	НИЙТ ДҮН	574	10,756.2	573	10,756.2

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дүрслэл №02 Зохих үр дүнд хүрсэн ТАХ-ний ангилал



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж зохих үр дүнд хүрсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г ангиллаар нь авч үзвэл;
 -Барилга байгууламж барихад 33.0 хувь буюу 3,562.9 сая төгрөг,
 -Гэрэлтүүлгийн ажилд 9 хувь буюу 991.0 сая төгрөг,
 -Худаг гаргах ажилд 4 хувь буюу 436.4 сая төгрөг,
 -Өвс, тэжээл бэлтгэхэд 14.0 хувь буюу 1,504.8 сая төгрөг,
 -Тоног төхөөрөмж худалдан авахад 16.0 хувь буюу 1,732.8 сая төгрөг,
 бусад ТАХ-д 24 хувь буюу 2,554.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.2.2. ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлснээр үр дүнд нөлөөлж орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр өгөхүйц ТАХ цөөхөн хэрэгжсэн байна

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн дараах ТАХ орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц үр нөлөөтэй ажил болсон байна. Үүнд:

Сумын ОНХС:

- Өлгий сумын 3, 4, 6, 9, 10, 11, 13 дугаар багуудад 128.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 гүний худаг гаргаснаар багийн айл өрхүүд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн 24 цагийн ундны цэвэр усаар хангагдсан;
- Өлгий сумын 1, 3, 4, 6, 8, 5, 10, 13 дугаар багуудад 225.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрэлтүүлэг шинээр татах, завсарлах /нарны цэнэгтэй ба цахилгааны эх үүсвэртэй/ 14 ажлын үр дүнд ард иргэдийн аюулгүй, амар тайван, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, хот гудамжны өнгө үзэмж сайжирсан;
- Өлгий сумын 12 дугаар багт 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ногоон байгууламжийн усалгааны шуудууг сэргээн засварласнаар ногоон байгууламжийн усалгааны систем хэвийн ажиллагаанд орж, тарьсан модыг байнгын усалгаатай болгосон;

Аймгийн ОНХС:

- Өлгий сумын 2 дугаар багт 208.0 сая төгрөгийн цэвэр усны шугам татах ажил хийгдсэнээр 10 гаруй айл өрх, Толбо сумын төвийн 5 дугаар багт 29.8 сая төгрөгийн гүний худаг гаргах ажил хийгдсэнээр 18-20 айл өрх эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байнгын ундны цэвэр усаар хангагдаж, ая тухтай амьдрах нөхцөл бүрдсэн;
- Өлгий сумын 12 дугаар багт 498.0 сая төгрөгийн цахилгаан хангамжийг сайжруулах төсөл хэрэгжсэнээр тус багийн 28 айл, өрх цахилгааны баталгаат эх үүсвэрээр хангагдсан;
- Улаанхус сумын Хөтөл багт 119.6 сая төгрөгийн Эрүүл мэндийн төвийн засварын ажил хийгдэж, 8 ортой болгон дахин ашиглалтад орсноор хөдөөгийн 1, 2, 11 дүгээр багуудын 860 гаруй айл, өрхийн 3,200 гаруй иргэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн байна.

Зураг №01 Ногоон байгууламжийн усалгааны шуудууг сэргээн засварласан байдал



Зураг №02 Нарны цэнэгтэй ба цахилгааны эх үүсвэртэй гэрэлтүүлгийн ажил



Зураг №03 Улаанхус сумын Хөх хөтөл багийн Эрүүл мэндийн төвийн засварын ажил



2.3.ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ЗОХИСТОЙ БАЙНА.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 98.6 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтдээ 10,783.7 сая төгрөгийн 574 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн 10,663.5 сая төгрөгийн 98.6 хувь буюу 563 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа бол 19.5 сая төгрөгийн 0.2 хувь буюу 1 төсөл арга хэмжээг зориулалтын бус ашиглаж байгаа, 100.7 сая төгрөгийн 1.2 хувь буюу 4 төсөл арга хэмжээний хөрөнгийг огт ашиглаагүй байна.
Хүснэгт:№ 10 Хөрөнгийн ашиглалтын байдал

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт						
		тоо	гэрээний дүн	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Зориулалтын бус ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ		
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	2	3	4	9	10	11	12	13	14	
1	Өлгий сум	62	780.5	58	717.0	1	19.5	3	44.0	
2	Алтай сум	24	324.4	24	324.4					
3	Алтанцөгц сум	16	186.4	16	186.4	0	-	0	0	
4	Баяннуур сум	25	296.9	25	296.9					
5	Булган сум	62	459.4	62	459.4	0	-	0	0	
6	Бугат сум	22	131.7	22	131.7			0	0	
7	Буянт сум	22	127.8	22	127.8					
8	Дэлүүн сум	24	172.6	24	172.6					
9	Ногооннуур сум	40	415.3	40	415.3	0	-	0	0	
10	Сагсай сум	25	863.3	25	863.3					
11	Толбо сум	35	344.8	35	344.8					
12	Улаанхус сум	61	730.5	61	730.5	0	-	0	0	
13	Цэнгэл сум	51	925.2	51	925.2					
14	Цагааннуур тосгон	8	41.0	8	41.0					
	сумын дүн	477	5,779.8	473	5,736.3	1	19.5	3	44.0	
15	Аймгийн дүн	97	4,983.9	93	4,927.2	0	-	4	56.7	
	НИЙТ ДҮН	574	10,783.7	566	10,663.5	1	19.5	7	100.7	

Зориулалтын бус ашигласан болон огт ашиглаагүй 120.2 сая төгрөгийн 8 ТАХ-г судалж үзэхэд ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн, хөрөнгийн хариуцагч тодорхойгүй, барилга байгууламжийг зориулалтын бус газарт барьж байгуулсан, чанаргүй хийгдсэн ТАХ байна.

Дүрслэл №03



ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн 574 ТАХ-ний үр дүнг ашиглагч байгууллагуудаас авсан судалгаанаас харахад 86.4 хувийг “Сайн”, 13.4 хувийг “Дунд”, 0.2 хувийг “Хангалтгүй” гэж үнэлсэн байна.

Аудитаар зориулалт бус ашигласан хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Сумын ОНХС:

- *Өлгий сумын 3-р багт ашиглалтад орсон 19.5 сая төгрөгийн гүний худгийг ЕБ-ын 10 дугаар сургуулийн хашааны дотор барьж байгуулснаас тухайн багийн айл өрхүүд ашиглах боломжгүй болсон;*
- *Өлгий сумын 6-р багт барьж байгуулсан 20.0 сая төгрөгийн гүний худаг зориулалтыг дагуу огт ашиглагдаагүй;*
- *Хот тохижуулах албаны ногоон байгууламжийн усалгааны системд нийлүүлсэн 8.0 сая төгрөгийн насос нь хэсэг хугацааны дараа эвдэрч, зориулалтын дагуу ашиглаж чадаагүй;*
- *Өлгий сумын 9-р багийн тоглоомын талбайг 16.0 сая төгрөгөөр засварласан боловч хариуцах эзэнгүйгээс эвдэрсэн байна.*

Дээрх зөрчлүүдээс дүгнэхэд захиалагч талаас ТАХ-ний хэрэгцээ шаардлага, хүртэх үр өгөөж, холбогдох тооцоо судалгааг бодитой тооцоогүй, гүйцэтгэгч нар ажил, үйлчилгээг чанаргүй гүйцэтгэснээс ашиглалтгүй хөрөнгүүд бий болсон байна.

Аудитын дүнгээр нийт 63.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2⁹, Сангийн сайдын баталсан 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12-д “ОНХС-ийн хөрөнгийн эх

⁹ Төсвийн хөрөнгөө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна

үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж заасан.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг ашиглагч байгууллага орлого авч бүртгэлд тусгаагүйгээс хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэх, ашиглалтгүй болох эрсдэл үүсдэг.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Сумын ОНХС:

- Өлгий сумын 9 дүгээр багийн тоглоомын талбайд 16.0 сая төгрөгөөр засвар хийгдсэн боловч хамгаалалтгүйгээс эвдэрч гэмтсэн;

Аймгийн ОНХС:

- Баяннуур сумын 3 дугаар цэцэрлэгийн 8.0 сая төгрөгийн гадна тохижилтын тоглоом, 10.5 сая төгрөгийн хатуу, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийг ажлын комисс хүлээн авч акт үйлдсэн боловч тус цэцэрлэг нь ашиглалтад ороогүйн улмаас сумын ЗДТГ-ын складад хадгалаастай, эзэнгүй орхигдсон;
- Шинээр ашиглалтад орох “Өлгий сумын хүүхдийн 28 дугаар цэцэрлэгийн 19.2 сая төгрөгийн зөөлөн эдлэл, 19.0 сая төгрөгийн хатуу эдлэлийг ажлын комисс хүлээн авч акт үйлдсэн боловч цэцэрлэг нь ашиглалтад ороогүй тул аймгийн Боловсролын газрын дансанд түр бүртгэсэн байна.

Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сул байгаагаас хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэх, ашиглалтгүй болох, хөрөнгийн байдал чанар алдах зэрэг төсвийн үргүй зардал нэмэгдэх эрсдэл бий болгож байна.

Аудитаар хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай холбоотой 1 албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

3.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗОХИХ ТҮВШИНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА

3.1.1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, дотоод аудит хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна

"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2¹⁰-д аймаг, сумын ИТХ нь тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг, мөн журмын 9.4¹¹-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний

¹⁰ Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

¹¹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт,

хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо, иргэний нийгмийн байгууллагууд, дотоод аудитын байгууллага нь хяналт тавьж ажиллахаар заасан.

Аудитын явцад аймаг, сумын ИТХ болон дотоод аудитын байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан эсэхийг шалгахад Алтай сумын ИТХ зохих түвшинд хяналтыг хэрэгжүүлэн ажилласан, Цэнгэл сумын ИТХ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний 78 хувь, Улаанхус сумын ИТХ нь 30 хувьд нь хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Харин бусад сумын ИТХ болон аймгийн ИТХ чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2024 онд аймаг, сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Аудитаар ОНХС-ийн хэрэгжилтэд чиг үүргийн дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй аймаг, сумын ИТХ, Засаг дарга нарт ОНХС-ийн журамд заасан чиг үүргийн дагуу хяналтыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

3.1.2.Захиалагчийн хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлэн ажилласан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд аймаг, сумын Засаг дарга ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж цаашид авах арга хэмжээг зохион байгуулан ажиллахаар заасан.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийтдээ 11,629.6 сая төгрөгийн 666 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Үүнээс сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 6,314.1 сая төгрөгийн 566 ТАХ-ээс 5,463.2 сая төгрөгийн 482 ТАХ буюу 85.6 хувьд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5,315.5 сая төгрөгийн 100 ТАХ-ээс 5,040.7 сая төгрөгийн 89 ТАХ буюу 90.0 хувьд нь Барилга захиалагч алба болон аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг зохих түвшинд хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт: Буянт сум 117.7 сая төгрөгийн 19 ТАХ, Ногооннуур сум 400.3 сая төгрөгийн 41 ТАХ, Улаанхус сум 107.0 сая төгрөгийн 13 ТАХ, Цэнгэл сум 225.8 сая төгрөгийн 11 ТАХ-ний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр ОНХС-ийн хэрэгжилтэд хууль тогтоомжийн дагуу хяналтыг хэрэгжүүлээгүй 4 сумын сумын Засаг даргад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.1.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын 78.8 хувийг хэрэгжүүлсэн байна.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргад 2 зөвлөмж, аймаг, сумын Засаг дарга болон холбогдох байгууллагуудад зөрчил арилгуулах 2,436.5 сая төгрөгийн 20 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 5 албан шаардлага хүргүүлсэн.

Өмнөх оны аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 79.7 хувьтай байна. Үүнээс Буянт сумын шийдвэрийн хэрэгжилт 66.7 хувь, Ногооннуур, Толбо, Өлгий сумын хэрэгжилт 50.0 хувь, аймгийн ОНХС-ийн зөрчлийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

Өмнөх аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийг давтан гаргаж, зөрчил арилгуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Үүнд:

- Булган сум иргэдээс авсан санал, эрэмбийн материалыг аудитын газарт ирүүлээгүй тул өмнөх аудитаар 106.7 сая төгрөгийн зөрчилд өгсөн албан шаардлагын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй;
- Булган, Ногооннуур сум ОНХС-ийн мэдээллийг УМС-д оруулаагүй, ил тод байдлыг хангаж ажиллаагүй;
- Толбо сум ОНХС-ийн хөрөнгөөр чанаргүй хийгдсэн ажлыг хүлээн авсан, хөрөнгийг зориулалт бус ашигласан, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн;
- Өлгий сумын ОНХС хөрөнгийг чиг үүрэгт хамааралтай боловч иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ-г баталж хэрэгжүүлсэн, ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орлогод авч, данс бүртгэлд тусгаагүй
- Аймгийн ОНХС-д аймгийн Засаг даргад иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт хамааралгүй ТАХ төлөвлөхгүй байх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитын дүнгээр зөрчлийг давтан гаргасан 1,088.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, ОНХС хариуцсан албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах 2 албан шаардлага хүргүүлэв.

3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАСАН БАЙНА.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу хугацаанд нь Сангийн яамд тайлагнасан байна.

Сумуудын санхүүгийн алба нь сумын ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд, Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс аймаг, сумын ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд хүлээн авч аймгийн төсвийн ерөнхий захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэгтгэлд оруулан тайлагнасан байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан хугацаанд 13 сум, 1 тосгоны ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг Аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст гаргаж ирүүлсэн байна.

Тус хэлтсээс журмын 9.9-д заасны дагуу сумуудаас авсан ОНХС-ийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 3-02/207 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтэст хугацаандаа хүргүүлсэн байна.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь сумуудын ОНХС-ийн хэрэгжилтийн тайланд журмын 9.3-д заасны дагуу дүн шинжилгээ хийгээгүй, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй, ямар нэг шийдвэр гараагүй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс ОНХС-ийн журмын 9.5-д заасны дагуу Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу ОНХС-ийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарах 7 зөвлөмж хүргүүлжээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаа үзэхэд шилжих хөрөнгө оруулалтад 3,444.3 сая төгрөг, барилга байгууламж, засварын ажилд 702.8 сая төгрөг, тоног төхөөрөмж, бусад худалдан авалтад 418.8 сая, төгрөгийг тус тус төлөвлөж, хэрэгжилтийг хангуулсан боловч 3 арга хэмжээ хэрэгжээгүй, хэрэгжилт 0 хувь байна. Үүнд:

"Шинэ Өлгий" хорооллын ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, Хүүхэд, залуусын биеийн тамирын цогцолбор байгууламжийн зураг, төсөв боловсруулах арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бодит нөхцөл боломж байхгүй, Өлгий сумын 8 дугаар багт явган хүний зам тавих ажлыг гүйцэтгэгч компани хугацаандаа багтаан хэрэгжүүлээгүй байна.

3.2.2.ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 248.7 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэсэн заасан.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглалтад оруулах комиссын актыг үндэслэн 8,308.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,562.7 сая төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагууд орлого авч данс бүртгэлд тусгасан, 1,535.7 сая төгрөгийн зарцуулалтыг урсгал зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Аудитаар аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэхийг шалгах явцад Баяннуур сумын 3 дугаар цэцэрлэгт “Мон Пик Цамхаг” ХХК нийлүүлсэн 8.0 сая төгрөгийн гадна тохижилтын тоглоом, 10.5 сая төгрөгийн хатуу, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын 2024 оны А/22, А/80 дугаар захирамжаар байгуулсан ажлын комисс хүлээн авч акт үйлдсэн боловч тус цэцэрлэг нь ашиглалтад ороогүй тул сумын ЗДТГ-ын складад хадгалагдсан, данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Өлгий сумын хүүхдийн 28 дугаар цэцэрлэгт “Худрет” ХХК нийлүүлсэн 19.2 сая төгрөгийн зөөлөн эдлэл, 19.0 сая төгрөгийн хатуу эдлэлийг аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны А/90 дугаар тушаалаар байгуулсан ажлын комисс хүлээн авч акт үйлдсэн боловч тус цэцэрлэг нь үйл ажиллагаагаа эхлээгүй байгаа тул аймгийн Боловсролын газрын дансанд бүртгэгдсэн байна.

Дээрх хөрөнгүүдийг ашиглагч байгууллагууд нь үйл ажиллагаагаа эхэлж данс бүртгэлдээ тусгах хүртэл хадгалалт, хамгаалалтад анхаарах шаардлагатай байна.

Аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагуудад орлого авч данс бүртгэлд тусгасан эсэхийг шалгахад нийт 248.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй зөрчил илэрсэн. Үүнд:

- Буянт сумын багийн төвийн аккумулятор 15.2 сая төгрөг;
- Ногооннуур сумын цагдаагийн тасгийн нисдэг дрон 7.0 сая төгрөг, автомашин 14.5 сая төгрөг, зөөврийн компьютер 5.0 сая төгрөг, Цаг уурын өртөөний хашаа 10.0 сая төгрөг, 2-р цэцэрлэгийн салбар бүлгийн хатуу зөөлөн эдлэл 4.5 сая төгрөг, 1-р цэцэрлэгийн салбар бүлгийн байр 19.0 сая төгрөг, аюулгүй нөөц бэлтгэх 16.4 сая төгрөг,
- Цагааннуур тосгоны сургууль, цэцэрлэгийн хөгжим 18.0 сая төгрөг, тэжээлийн аюулгүй нөөц 36.9 сая төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх GPS 4.0 сая төгрөг;
- Улаанхус сум хурлын заалны тавилга 19.0 сая төгрөг, Багийн конторын тавилга 6.0 сая төгрөг, Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 20.0 сая төгрөг, өвс тэжээлийн нөөц бэлдэх 37.2 сая төгрөг;
- Өлгий сум 9-р багийн тоглоомын талбайн засвар 16.0 сая төгрөг;

Аудитын дүнгээр дээрх хөрөнгүүдийг ашиглагч байгууллагуудад орлого авхуулж данс бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөв.

3.2.3. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд 2 сум мэдээллийг оруулаагүй байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 10.2-т заасны дагуу аймаг, сумын ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд оруулж, ил тод мэдээлэх журамтай.

Аймгийн ИТХ-аар баталж аймгийн ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,106.0 сая төгрөгийн 112 ТАХ-г удирдлага мэдээллийн системд бүрэн оруулсан байна.

Сумын ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 8,683.2 сая төгрөгийн 674 ТАХ-ний 6,558.3 сая төгрөгийн 469 ТАХ-г мэдээллийн системд оруулсан байна.

Дэлүүн сум мэдээлэл дутуу оруулсан, Булган, Ногооннуур сум удирдлагын мэдээллийн системд мэдээлэл огт оруулаагүй байна.

Хүснэгт №11 Аймаг, сумын ОНХС-ийн мэдээллийг УМС-д мэдээлсэн байдал

(сая төгрөг)

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн		
1	Алтай сум	28	367.0	28	367.0				
2	Алтанцөгц сум	20	369.3	20	369.3				
3	Баяннуур сум	40	639.4	40	639.4				
4	Бугат сум	33	230.8	33	230.8				
5	Булган сум	77	577.8					77	577.8
6	Буянт сум	22	187.8	22	187.8				
7	Дэлүүн сум	67	815.2			67	815.2		
8	Ногооннуур сум	61	731.9					61	731.9
9	Сагсай сум	28	935.9	28	935.9				
10	Толбо сум	73	747.9	73	747.9				
11	Улаанхус сум	82	932.1	82	932.1				
13	Цэнгэл сум	66	1,230.1	66	1,230.1				
12	Цагааннуур тосгон	9	50.0	9	50.0				
14	Өлгий сум	68	867.9	68	867.9				
	Сумын дүн	674	8,683.1	469	6,558.2	67	815.2	138	1,309.7
	Баян-Өлгий аймгийн ОНХС	112	6,106.1	112	6,106.1				
	Нийт дүн	786	14,789.2	581	12,664.3	67	815.2	138	1,309.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитаар удирдлагын мэдээллийн системд мэдээллийг огт оруулаагүй, зөрчлийг давтан гаргасан Булган, Ногооннуур сумын орон нутгийн хөгжлийн сан хариуцсан албан тушаалтануудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөв.

Аудитын явцад Буянт, Толбо, Цэнгэл сумдын ОНХС-ийн УМС-д дутуу оруулсан нийт 2,165.8 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаатай үүрэг өгч, нөхөж оруулах арга хэмжээ авч зөрчлийг арилгуулсан.

ОНХС хариуцсан албан тушаалтнууд ажилдаа хайнга хандсан, тухайн байгууллагын дотоод хяналт сул байгаагаас УМС-д мэдээллийг оруулаагүй байна.

3.2.4 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж ажилласан. Энэхүү гүйцэтгэлийн аудитаар давтан шалгахад зөрчил илрээгүй байна.

Аймгийн ОНХС, 13 сум болон Цагааннуур тосгоны ОНХС-ийн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулах мэдээллийг хугацаанд нь оруулж, хууль журмыг хэрэгжүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Малын тоо, толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт хангалтгүй байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 44.2 хувь нь иргэдийн саналаар дэмжигдэгүй байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулсан байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний 93.0 хувийг гэрээ шууд байгуулан жижиг ТАХ-д зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнд нөлөөлж байна.
5. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, дотоод аудит хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын 21.2 хувийг хэрэгжүүлээгүй байна.
7. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

I. Аймгийн ИТХ-ын дарга / А.Бегарыс/-д:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллах;
2. Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлахгүй байх;

II. Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулж, аймгийн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа асуудалд дүгнэлт хийж, тэргүүлэх чиглэлд нийцсэн үр өгөөжтэй ТАХ төлөвлөж хэрэгжүүлэх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналтыг хэрэгжүүлэн ажиллах;

III. Сумын Засаг дарга нарт:

1. Малын тоо, толгойн татвараас орох орлогыг бодитой тооцож, ОНХС-гийн төлөвлөгөөнд нэмж төлөвлөх, ОНХС-ийн журамд заасан чиг үүргийн хүрээнд орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г санхүүжүүлэх;
2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулж, тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаа асуудалд дүгнэлт хийж, тэргүүлэх чиглэлтэй нийцсэн үр өгөөжтэй ТАХ төлөвлөж ажиллах;

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Орон нутгийн ээлжит сонгуулийн дараах улс төрийн томилгоо, ОНХС хариуцсан албан тушаалтны ажлын байрны тогтворгүй байдлаас үүдэлтэй аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй, зөрчил жил бүр давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж хариуцлагын асуудлыг хууль тогтоомжид оруулах асуудлыг УИХ-д санал болгох;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр эрэмбэлсэн, иргэдийн санал авсан ТАХ-ний ихэнх нь хэт жижиг, хэсэг хүмүүсийн эрх ашгийг хөндсөн ТАХ-г төлөвлөж хэрэгжүүлдэг нь удаа дараагийн аудитаар илэрч байгаа тул урт, дунд хугацааны болон жилийн хөгжлийн төлөвлөгөө, мөрийн хөтөлбөрт тусгагдсан, ТЭЗҮ, зураг төсөв бусад зөвшөөрөл нь олгогдсон орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г иргэдийн санал авсан эсэхийг харгалзахгүйгээр аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор баталж хэрэгжүүлэх талаар Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах асуудлыг холбоглох байгууллагуудад тавих.


БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/19

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (А.Бегарыс), Засаг дарга (Е.Зангар) болон сумын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 7 хоногт багтаан аудитын тайлан болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэж өгөхийг ахлах аудитор (У.Ербол)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Женисбек)-т тус тус даалгасугай.



Ж.АЙГҮЛ

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 01-ны
өдрийн 11/10 дугаар тушаалын 04 дугаар хавсралт

8317144071
БНДА0074 900 245

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн"
сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын
жагсаалт

№	Аймаг, сумын нэр	Нийт зөрчил		Үүнээс			
				Акт		Албан шаардлага	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Булган сум	2	70,000.0			2	70,000.0
2	Бугат сум	2	68,000.0			2	68,000.0
3	Буянт сум	1	222,536.1			1	222,536.1
4	Ногооннуур сум	2	652,707.7			2	652,707.7
5	Толбо сум	1	703,742.7			1	703,742.7
6	Улаанхус сум	2	140,605.0	1	2,405.0	1	138,200.0
7	Цэнгэл сум	1	455,833.7			1	455,833.7
8	Өлгий сум	1	320,900.0			1	320,900.0
9	Аймаг ОНХС	3	1,507,031.2			3	1,507,031.2
	Дүн	15	4,141,356.4	1	2,405.0	14	4,138,951.4




**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

5 дугаар баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83129
Утас/Факс: (976) 7042 3377,
Цахим шуудан: contact@bayan-olgi.khural.mn,
Цахим хуудас: www.bayan-olgi.khural.mn

2025.07.02 № 02/2025
талай _____ -ны № _____ -т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой ямар нэгэн санал байхгүй болно.

НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.БАРШАГУЛ



8325050243



МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603
Цахим шуудан: info@bo.gov.mn
Цахим хаяг: http://www.bayan-olgi.gov.mn/

2025.07.05 № 2-01/2025
танай 2025.07.01 ны № 545 -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Аймгийн "Орон нутгийн хөгжлийн сангийн
2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө
сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай
холбоотой ямар нэгэн санал байхгүй болно.

ОРЛОГЧ



К.БАХЫТЖАН

8325091401